



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/178/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК -гэрээт аудитор:
Б.Цэрэндэжид

Утас: 99812811

Цахим хаяг: tserendejid1109@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН АУДИТЫН АЖИРААГА
Улсын Фам: 7046-30-12
Нийслэл: Завхангай сумын төв

2025.02.21 № 213

Хугацаа

№

ЦАГААНХАЙРХАН СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Л ЛХАГВАСҮРЭН-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагаанхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаанхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Цагаанхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 63 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт 95.7 хувьтай дүгнэгджээ. Цэцэрлэгийн 60 жилийн ойн хүрээнд иргэдийн хандиваар 2,260.1 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Аудитын гол асуудал

Цагаанхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 90 нэр төрлийн 47,258.7 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлж ашиглах хугацааг сунгаагүй, хүүхдийн хоолыг нормативт зардлаас 351.9 мянган төгрөг дутуу олгосон, 2,343.2 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Цагаанхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэг нь Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 5,674.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнийг

Discuss/Анбан бичиг/Дүгнэлт

812502366

данс бүртгэлд тусгасан байна тус цэцэрлэг нь Цагаанхайрхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 32 дугаар тогтоолоор 1,220.6 мянган төгрөгийн тавилга эд хогшил, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/45 дугаар захирамжаар 4,342.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 250.0 мянган төгрөгийн программ хангамжийг акталж, данс бүртгэлээс хассан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	91,037,636.40	110,728,543.31
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	26,008,478.59	41,077,856.20
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	26,008,478.59	41,077,856.20
3121	Төгрөг	26,008,478.59	41,077,856.20
31211	Төрийн сангийн харилцах	26,008,478.59	41,077,856.20
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА		3,641,474.30
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		3,641,474.30
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	65,029,157.81	66,009,212.81
351	Түүхий эд материал	12,580,240.00	15,504,840.00
3511	Тусгай зориулалттай материал	12,420,240.00	15,358,840.00
3513	Эм боох материал	160,000.00	146,000.00
354	Хангамжийн материал	44,548,917.81	44,684,372.81
3541	Бичиг хэргийн материал	588,950.00	415,900.00
3542	Аж ахуйн материал	623,900.01	714,400.01
3543	Сэлбэг хэрэгсэл	560,900.00	850,900.00
3544	Түлш, шатах тослох материал	463,500.00	463,500.00
3545	Барилгын засварын материал	6,583,400.00	7,691,550.00
3546	Хүнсний материал	15,803,806.80	14,378,661.80
3547	Бусад хангамжийн материал	19,924,461.00	20,169,461.00
356	Мал амьтад	7,900,000.00	5,820,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	515,861,985.31	504,802,707.46
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	515,861,985.31	504,802,707.46
392	Биет хөрөнгө	508,064,985.31	497,088,207.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	526,948,321.75	526,948,321.75
39202	Хуримтлагдсан элэгдэл	-73,429,277.40	-88,115,132.88
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28,516,640.00	42,702,240.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-14,597,410.26	-20,188,860.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,006,619.65	55,666,619.65
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,193,928.43	-22,739,000.76
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,712,200.00	1,712,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,712,200.00	-1,712,200.00
39217	Ном	2,814,020.00	2,814,020.00
393	Биет бус хөрөнгө	7,797,000.00	7,714,500.00

39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,155,000.00	-1,237,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,302,000.00	7,302,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	606,899,621.71	615,531,250.77
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
413	Өглөг		
414	Урьдчилж орсон орлого		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
422	Урт хугацаат зээл		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	606,899,621.71	615,531,250.77
51	Засгийн газрын хувь оролцоо	606,899,621.71	615,531,250.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	39,267,503.00	39,267,503.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	39,267,503.00	39,267,503.00
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	557,588,678.48	566,220,307.54
5121	Өмнөх үеийн үр дүн	557,588,678.48	557,588,678.48
5122	Тайлант үеийн үр дүн		8,631,629.06
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,043,440.23	10,043,440.23
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	606,899,621.71	615,531,250.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	430,060,721.00	572,471,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,650,621.00	14,220,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	19,650,621.00	14,220,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	185,000.00	35,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	185,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	11,176,021.00	14,185,600.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	8,289,600.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	410,410,100.00	558,250,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	366,367,800.00	507,974,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	366,367,800.00	507,974,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,042,300.00	50,276,800.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,042,300.00	50,276,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	424,721,061.97	563,839,870.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	424,721,061.97	563,839,870.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	423,916,341.86	561,614,883.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	277,847,233.28	388,667,009.54
210101	Үндсэн цалин	198,604,314.28	246,075,316.79
210102	Нэмэгдэл	71,004,754.00	129,601,142.75
210104	Урамшуулал	8,238,165.00	12,990,550.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,942,238.13	48,776,868.55
210201	Тэтгэврийн даатгал	24,139,609.34	34,044,370.27
210202	Тэтгэмжийн даатгал	2,839,954.03	3,922,250.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,254,363.22	2,057,976.85
210204	Ажилгүйдлийн даатгал	502,527.88	1,707,017.59
210205	Эрүүл мэндийн даатгал	5,205,783.66	7,045,253.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,533,729.89	44,946,912.88
210301	Гэрэл, цахилгаан	3,259,729.89	3,323,472.88
210302	Түлш, халаалт	34,848,000.00	35,167,440.00
210303	Цэвэр, бохир ус	1,426,000.00	6,456,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,053,800.00	5,851,100.00
210401	Бичиг хэрэг	842,800.00	2,128,500.00
210402	Тээвэр, шатахуун	661,000.00	408,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	810,000.00	1,233,800.00
210408	Бараа материал акталсны зардал	4,740,000.00	2,080,000.00
2105	Нормативт зардал	34,202,280.00	38,699,515.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	95,900.00	160,000.00
210502	Хоол, хүнс	34,106,380.00	38,539,515.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,315,850.00	1,996,750.00
210604	Урсгал засвар	1,315,850.00	1,996,750.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	255,430.00	1,187,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	255,430.00	1,187,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,765,780.56	31,489,427.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,911,900.00	5,549,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,052,160.00	35,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,801,730.56	25,904,877.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	804,720.11	2,224,987.12
2132	Бусад урсгал шилжүүлэг		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		2,224,987.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		2,224,987.12

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	804,720.11	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	804,720.11	
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,339,659.03	8,631,629.06
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,120,000.00	
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	1,120,000.00	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,120,000.00	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	4,219,659.03	8,631,629.06

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	410,595,100.00	558,285,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	185,000.00	35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	185,000.00	35,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	185,000.00	35,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	185,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	410,410,100.00	558,250,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	366,367,800.00	507,974,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	366,367,800.00	507,974,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,042,300.00	50,276,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,042,300.00	50,276,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	403,780,751.41	542,556,522.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	403,780,751.41	542,556,522.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	402,976,031.30	540,331,535.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	277,847,233.28	392,308,483.84
210101	Үндсэн цалин	196,533,269.67	261,235,648.87
210102	Нэмэгдэл	73,475,589.10	118,596,357.08
210104	Урамшуулал	7,838,374.51	12,476,477.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,942,238.13	48,776,868.55
210201	Тэтгэврийн даатгал	24,139,609.34	34,044,370.27
210202	Тэтгэмжийн даатгал	2,839,954.03	3,922,250.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,236,291.10	2,057,976.85
210204	Ажилгүйдлийн даатгал	520,600.00	1,707,017.59

210205	Эрүүл мэндийн даатгал	5,205,783.66	7,045,253.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,875,629.89	44,946,912.88
210301	Гэрэл, цахилгаан	4,601,629.89	3,323,472.88
210302	Түлш, халаалт	34,848,000.00	39,523,440.00
210303	Цэвэр, бохир ус	1,426,000.00	2,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал	38,713,650.00	37,114,370.00
210502	Хоол, хүнс	38,713,650.00	37,114,370.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,361,950.00	3,104,900.00
210604	Урсгал засвар	2,361,950.00	3,104,900.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	579,430.00	1,187,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	579,430.00	1,187,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,655,900.00	12,892,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,875,500.00	9,087,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,780,400.00	3,805,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	804,720.11	2,224,987.12
2132	Бусад урсгал шилжүүлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		2,224,987.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		2,224,987.12
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	804,720.11	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	804,720.11	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	6,814,348.59	15,729,377.61
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) Дотоод эх үүсвэрээр	1,520,000.00	660,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,520,000.00	660,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) 145 Бусад эх үүсвэр 25 Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-1,520,000.00	-660,000.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) 31 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл 31 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,294,348.59	15,069,377.61 26,008,478.59 41,077,856.20

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Цагаанчулуут цэцэрлэг

Тайлант хугацаа: 2024.12.31

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2023. оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	39,267,503.00	10,043,440.23	557,588,678.48	606,899,621.71
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
8	Тайлант үеийн үр дүн			8,631,629.06	8,631,629.06
9				
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	39,267,503.00	10,043,440.23	566,220,307.54	615,531,250.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Цагаанчулуут цэцэрлэг

Тайланг хугацаа: 2024.12.31

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	585,982,300.00	543,816,522.39	42,165,777.61	92.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	585,982,300.00	543,216,522.39	42,765,777.61	92.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	585,982,300.00	540,991,535.27	44,990,764.73	92.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	428,534,100.00	392,308,483.84	36,225,616.16	91.55
210101	Үндсэн цалин	287,813,000.00	261,235,648.87	26,577,351.13	90.77
210102	Нэмэгдэл	137,149,400.00	118,586,357.08	18,553,042.92	86.47
210104	Урамшуулал	3,571,700.00	12,476,477.89	-8,904,777.89	349.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,438,600.00	48,776,868.55	2,661,731.45	94.83
210201	Тэтгэврийн даатгал	34,978,800.00	34,044,370.27	934,429.73	97.33
210202	Тэтгэмжийн даатгал	4,114,600.00	3,922,250.58	192,349.42	95.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,057,500.00	2,057,976.85	-476.85	100.02
210204	Ажилгүйдлийн даатгал	2,057,500.00	1,707,017.59	350,482.41	82.97
210205	Эрүүл мэндийн даатгал	8,230,200.00	7,045,253.26	1,184,946.74	85.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,171,800.00	44,946,912.88	2,224,887.12	95.28
210301	Гэрэл, цахилгаан	4,858,100.00	3,323,472.88	1,534,627.12	68.41
210302	Түлш, халаалт	41,085,700.00	39,523,440.00	1,562,260.00	96.2
210303	Цэвэр, бохир ус	1,228,000.00	2,100,000.00	-872,000.00	171.01
2104	Хангамж, бараа материалын зардал				
2105	Нормативт зардал	37,954,100.00	37,114,370.00	839,730.00	97.79
210502	Хоол, хүнс	37,954,100.00	37,114,370.00	839,730.00	97.79
2106	Эд хопшил, урсгал засварын зардал	3,105,000.00	3,104,900.00	100	100
210604	Урсгал засвар	3,105,000.00	3,104,900.00	100	100
2107	Томилголт, зочны зардал				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,187,300.00	1,187,300.00		100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,187,300.00	1,187,300.00		100

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,591,400.00	13,552,700.00	3,038,700.00	81.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,095,800.00	9,747,200.00	1,348,600.00	87.85
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,495,600.00	3,805,500.00	1,690,100.00	69.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,224,987.12	-2,224,987.12	
2132	Бусад урсгал шилжүүлэг				
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		2,224,987.12	-2,224,987.12	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		2,224,987.12	-2,224,987.12	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		600,000.00	-600,000.00	
	Дотоод эх үүсвэрээр		600,000.00	-600,000.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		558,285,900.00	558,285,900.00	-
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		507,974,100.00	507,974,100.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих		507,974,100.00	507,974,100.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		50,276,800.00	-50,276,800.00	
132001	Орон нутгийн төсвөөс		50,276,800.00	-50,276,800.00	
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС				
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		35,000.00	-35,000.00	
1200042	Тусгах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.00	-35,000.00	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		26,008,478.59	-26,008,478.59	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		41,077,856.20	-41,077,856.20	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100
3	Төсвийн байгууллага	1	1		100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
6	Удирдах ажилтан	1		1	
7	Гүйцэтгэх ажилтан	10	11	-1	110
8	Үйлчлэх ажилтан	5	5		100
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Нэмэлт санхүүжилт байхгүй

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэл:

- Сургуулийн өмнөх боловсрол олгох

Хүүхдийн цэцэрлэгийн зорилго: Суралцагчийн эзэмших чадамж /танин мэдэхүй, эрүүл мэнд, нийгэм- сэтгэл хөдлөл/-ийг хөгжүүлэхэд бүх талын оролцоо хамтын ажиллагааг ханган хөгжүүлэх үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 83.1 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
11. Хөдөлмөрийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд орсон өөрчлөлт: 2024 оны 03 сарын 27-ны 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тотоосон, Боловсролын ерөнхий хууль 2024 оны 07-р сарын 07-нд батлагдсан. Засгийн газрын 2024 оны 08 сарын 28-ны 53 дугаар тогтоолоор "Хувьсах зардлыг хэмжээ, итгэлцүүр" шинэчлэгдэн батлагдсан, Сангийн Сайдын 2024 оны 04 сарын 01-ний А/52 тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсан. Мөн Засгийн газрын 2024 оны 05 сарын 29-ний 237 дугаар тогтоолоор "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 8,631.0 мянган төгрөгөөр буюу 1.42 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага		3,641.5	3,641.5
Бараа материал	65,029.2	66,009.2	980.0
Үндсэн хөрөнгө	515,862.0	504,802.7	11,059.3
Нийт хөрөнгө	580,891.2	574,453.4	6,437.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	606,899.6	615,531.2	8,631.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	606,899.6	615,531.2	8,631.6

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Бараа материалын эхний үлдэгдэл 65,029.2 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 47,527.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 44,547.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулж эцсийн үлдэгдэл 66,009.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 980.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 660.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 14,185.6 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж жилийн эцэст 638,795.4 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 25,904.9 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 8,631.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 447,417.68 мянган төгрөг, нийт зарлагыг 447,417.68 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 447417.68 мянган төгрөгийг улсын төсөвт суллуулахаар төсөвлөсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 543,816.5 мянган төгрөг буюу 92.8 хувьтай байна. Энэ нь цалингийн зардал 36,225.6 НДШ-ийн зардал 2,661.7 байр ашиглалтай холбоотой зардал 2,224.8 хоол 13,461,7 Урсгал засвар 0.1 Бараа үйлчилгээний бусад зардал 3,038.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
71801	Сургуулийн өмнөх боловсрол				
80233	Хүүхэд хамгаалал	500.9	500.9		100%
81605	Эрүүл мэндийг дэмжих	878.7	878.7	-	100%
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	37,954.1	37,114.4	839.7	97.79%
81816	Зөв монгол хүүхэд	1,960.0	1,953.0	7.1	99.64%
81823	Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	878.7	340.0	578.7	38.69%
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжүүлэх	490,157.0	450,504.7	39,652.3	91.91%
81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах	1,688.0	1,688.0		100%
НИЙТ		1,733,161.9	1,613,709.2	119,452.7	93.1%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Байхгүй

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

<i>/мянган төгрөг/</i>				
№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт	Хүүхдийн байрын хүүхдийн хоол	37,954.1	37,114.4
ДҮН			37,954.1	37,114.4

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124

дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Хаан соёмбо аудит ХХК”-ны гэрээт аудитор Б.Цэрэндэжид гүйцэтгэж, анхан шатны хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд хийж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна. засах

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 563,839.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 5,638.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4,510.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 576.9 мянган төгрөгийн актын төлбөрын 100% төлж барагдуулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	576.9	1	576.9	100%
Нийт дүн	1	576.9	1	576.9	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байгаагүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 952.2 мянган төгрөгийн алдаа илэрч зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

Байхгүй

Шийдвэрлэсэн байдал: Байхгүй

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж

Илэрсэн алдаа: Хүүхдийн хоолыг нормативт зардлаас 952.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" заалт, Засгийн газрын 2019 оны 450, 2024 оны 237 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэн ажиллах

Илэрсэн алдаа: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 32 төрлийн 16,523.0 мянган төгрөгийн хөрөнгө элэгдээрээ анхны өртгөө нөхсөн үлдэгдэл өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭЛТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэлтгэл

Үүнээс

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хүүхдийн Хоолны зардлыг нормативаас дутуу зарцуулсан	1	952.2					1	952.2				
Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн 0 үлдэгдэлтэй байгаа 32 нэр төрлийн 16,523,050.82 төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж ашиглалтын хугацааг сулгах	1						1					
		952.2					952.2					

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Огноо: 2025-01-18 9339376

БОЛОВСРУУЛСАН:

"ХААН СОЁМО АУДИТ" ХХК ГЭРЭЭТ АУДИТОР

Огноо: 2025-01-18

Б.ЦЭРЭНДЭЖИД

